



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2000 оны 12 дугаар
сарын 21-ны өдөр

Дугаар 45.7

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлж, ажилд
томилох тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Улаанбаатар хотын Захирагчийн харъяа байгууллагуудын бүтцийг шинэчлэн тогтоож байгаатай холбогдуулан О.Эрдэнэбаатарыг Ус суваг ашиглалтын газрын, Г.Мөнхбаярыг Орон сууц, нийтийн аж ахуйн компаний, Г.Өлзийг Хөрөнгө оруулалт, хот тохижилтын газрын, Н.Нямдавааг Тээвэр зохицуулалтын газрын, Л.Балдан-Очирыг Халаалтын зуухны ашиглалтын төвийн, П.Дэлгэрнарэнг Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн, С.Дагийсүрэнг Иргэдэд үйлчлэх “Буян” компаний, Б.Отгонсүрэнг “Улаанбаатар зам засвар” компаний, Ж.Амгаабазарыг “Гэрэлтүүлэг чимэглэл” компаний, Д.Наранг “Нөөц” компаний, Ө.Магсаржавыг “Цэцэрлэгжилт” компаний дарга, захирлын үүрэгт ажлаас 2000 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөр тасалбар болгон тус тус чөлөөлсүгэй.

Хоёр. Улаанбаатар хотын Захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд ажиллах харъяа байгууллагуудын даргаар дараах нэр бүхий хүмүүсийг 2000 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн томилон ажиллуулсугай.

Ус суваг ашиглалтын газрын даргаар Осорын Эрдэнэбаатар
Орон сууц, нийтийн аж ахуйн газрын даргаар Гомбосүрэнгийн Мөнхбаяр,
Хөрөнгө оруулалтын газрын даргаар Гүнтэвийн Өлзий
Тээврийн газрын даргаар Төгсийн Пүрэвдорж
Халаалтын зуухны ашиглалтын газрын даргаар Хайнжамцын Бүрэнтогтох
Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн захирлаар Раднаагийн Зоригт
Иргэдэд үйлчлэх “Буян” компаний захирлаар Содномжамцын Дагийсүрэн
“Улаанбаатар зам засвар” компаний захирлаар Хашийн Энхтайван
“Гэрэлтүүлэг чимэглэл” компаний захирлаар Жамбалын Амгаабазар
“Нөөц” компаний захирлаар Должидийн Наран
“Цэцэрлэгжилт” компаний захирлаар Өлзий-Утасын Магсаржав

Гурав. Улаанбаатар хотын Захирагчтай зөвшилцсөний үндсэн дээр Захирагчийн харъяа байгууллагын удирдлагуудын цалин, нэмэгдлийг тогтоож, тэдэнтэй гэрээ байгуулан мөрдүүлж ажиллахыг Өмчийн харилцааны газар /П.Дэлгэрнарэнг/-т зөвшөөрсүгэй.

Дөрөв. Байгууллагын дүрмээ шинэчлэн боловсруулж бүтэц, орон тооны тухай саналаа 2000 оны 12 дугаар сарын 28-ны дотор багтаан Улаанбаатар хотын Захирагчид танилцуулахыг харъяа байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

Тав. Харьяа байгууллагуудын бүтцийг шинэчлэн тогтоож байгаатай холбогдуулан Л.Балдан-Очир, Н.Нямдаваа нарыг Захирагчийн ажлын албаны, Б.Отгонсүрэнг хотын Яаралтай тусламжийн төвийн мэдэлд тус тус шилжүүлсүгэй.


Зургаа. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны зарим хэлтэс болон Тээврийн газар, Халаалтын зуухны ашиглалтын газар, Үндэсний соёл амралтын хүрээлэн, “Улаанбаатар зам засвар” компаний удирдлагуудын ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга	Т.Бадамжунай	-Хотын ерөнхий менежер, Захирагчийн ажлын албаны дарга
	Т.Цэрэндэжид	-Захирагчийн ажлын албаны хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан
	Г.Анхныбаяр	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн зохион байгуулагч
	Д.Цэрмаа	-Захирагчийн ажлын албаны нягтлан бодогч -Тухайн байгууллагын ахлах нягтлан бодогч, хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан нар

Зургаа. Л.Балдан-Очир, Б.Отгонсүрэн, Н.Нямдаваа, П.Дэлгэрнарантай амралтын болон холбогдох бусад тооцоог хийхийг байгууллагуудын нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ


М.ЭНХБОЛД